

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ 2 ДУГААР  
САРЫН ӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн өсвийн 2010 оны 2 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2010 оны 2 дугаар сарын байдлаар нэгдсэн өсвийн нийт орлогын бүрдүүлэлт 109.3 хувийн биелэлттэй, нийт зарлага 69.6 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн нийт алдагдал 51.4 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 192.3 тэрбум төгрөгөөр бага байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

**А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:**

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2010 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр 326.7 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 27.7 тэрбум төгрөгөөр буюу 9.3 хувиар давж биелж, 2009 оны мөн үеийнхээс 84.5 хувиар буюу 149.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын төрлөөр авч үзвэл:**

| ӨСВИЙН ОРЛОГО                              | НЭГДСЭН ТӨСӨВ      |                  |                  |              |              |             |             |
|--|--------------------|------------------|------------------|--------------|--------------|-------------|-------------|
|  | ӨО-ны<br>мөн үеийн | жилийн<br>Төлөв. | 2010 ОНЫ 2-Р САР |              | ХУВЬ         |             | ӨРҮҮ        |
|  | 1                  | 2                | Төлөв.<br>3      | Гүйцэт.<br>4 | (4:3)<br>5   | (4:2)<br>6  | (4-3)<br>7  |
|  | ( Тэрбум төгрөг )  |                  |                  |              |              |             |             |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>       | <b>177.1</b>       | <b>2,427.0</b>   | <b>299.0</b>     | <b>326.7</b> | <b>109.3</b> | <b>13.5</b> | <b>27.7</b> |
| УРСГАЛ ОРЛОГО                              | 176.8              | 2,403.4          | 298.7            | 311.8        | 104.4        | 13.0        | 13.1        |
| <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                     | <b>160.3</b>       | <b>2,083.7</b>   | <b>267.5</b>     | <b>280.3</b> | <b>104.8</b> | <b>13.5</b> | <b>12.7</b> |
| Орлогын албан татвар                       | 43.2               | 698.6            | 104.5            | 116.2        | 111.3        | 16.6        | 11.8        |
| ААН-ийн орлогын албан татвар               | 27.3               | 268.8            | 40.0             | 60.8         | 152.0        | 22.6        | 20.8        |
| Хувь хүний орлогын албан татвар            | 15.8               | 119.2            | 18.0             | 18.2         | 101.3        | 15.3        | 0.2         |
| Зарим үгтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар | 0.2                | 310.6            | 46.5             | 37.2         | 80.0         | 12.0        | -9.3        |
| Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж        | 28.0               | 278.6            | 35.8             | 35.9         | 100.5        | 12.9        | 0.2         |
| Өмчийн татвар                              | 1.0                | 10.5             | 1.1              | 1.1          | 102.2        | 10.3        | 0.0         |
| Дотоодын бараа, үйлчилгээний татвар        | 61.0               | 696.0            | 84.6             | 83.9         | 99.1         | 12.0        | -0.8        |
| Гадаад худалдааны орлого                   | 14.1               | 153.1            | 17.8             | 18.2         | 102.1        | 11.9        | 0.4         |
| Бусад татвар                               | 13.1               | 246.8            | 23.8             | 25.0         | 104.8        | 10.1        | 1.2         |
| <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                 | <b>16.5</b>        | <b>319.7</b>     | <b>31.2</b>      | <b>31.5</b>  | <b>101.1</b> | <b>9.9</b>  | <b>0.3</b>  |
| <b>ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>                    | <b>0.3</b>         | <b>1.6</b>       | <b>0.3</b>       | <b>0.3</b>   | <b>118.7</b> | <b>20.3</b> | <b>0.1</b>  |
| <b>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</b>                   | <b>0.0</b>         | <b>22.0</b>      | <b>0.0</b>       | <b>14.5</b>  | <b>0.0</b>   | <b>66.1</b> | <b>14.5</b> |

Монгол Улсын нэгдсэн өсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 85.8 хувь нь татварын орлогоос, 9.6 хувь нь татварын бус орлогоос, 4.5 хувь нь тусламжийн орлогоос, 0.1 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар 20.8 тэрбум өгрөгөөр давж биелсэн, АНУ-аас нийгмийн халамжийн зардалд зориулж 10.0 сая ам.долларын тусламж олгосон нь нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

## Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:

| ӨСВИЙН ОРЛОГО                              | Улсын өсөв       |              | Орон нутгийн өсөв |             | ХХС        |            | НДС         |             |
|--|------------------|--------------|-------------------|-------------|------------|------------|-------------|-------------|
|  | ТӨЛ              | ГҮЙ          | ТӨЛ               | ГҮЙ         | ТӨЛ        | ГҮЙ        | ТӨЛ         | ГҮЙ         |
|  | (Тэрбум.төгрөг ) |              |                   |             |            |            |             |             |
| <b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>       | <b>244.2</b>     | <b>261.8</b> | <b>35.0</b>       | <b>37.7</b> | <b>8.3</b> | <b>9.7</b> | <b>77.1</b> | <b>75.9</b> |
| УРСГАЛ ОРЛОГО                              | 224.4            | 233.3        | 30.2              | 32.8        | 8.3        | 9.7        | 46.9        | 45.7        |
| ТАТВАРЫН ОРЛОГО                            | 195.5            | 203.7        | 28.0              | 31.0        | 8.3        | 9.7        | 46.9        | 45.7        |
| <b>Орлогын албан татвар</b>                | <b>86.5</b>      | <b>98.0</b>  | <b>18.0</b>       | <b>18.2</b> | <b>0.0</b> | <b>0.0</b> | <b>0.0</b>  | <b>0.0</b>  |
| ААН-ийн орлогын албан татвар               | 40.0             | 60.8         | 0.0               | 0.0         | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| Хувь хүний орлогын албан татвар            | 0.0              | 0.0          | 18.0              | 18.2        | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| Зарим ҮТЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТИЙН А/ТАТВАР | 46.5             | 37.2         | 0.0               | 0.0         | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| <b>Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж</b> | <b>0.0</b>       | <b>0.0</b>   | <b>0.0</b>        | <b>0.0</b>  | <b>0.0</b> | <b>0.0</b> | <b>46.9</b> | <b>45.7</b> |
| <b>Өмчийн татвар</b>                       | <b>0.0</b>       | <b>0.0</b>   | <b>1.1</b>        | <b>1.1</b>  | <b>0.0</b> | <b>0.0</b> | <b>0.0</b>  | <b>0.0</b>  |
| Дотоодын бараа, үйлчилгээний татвар        | 84.5             | 83.8         | 0.1               | 0.1         | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| Гадаад худалдааны орлого                   | 17.8             | 18.2         | 0.0               | 0.0         | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| Бусад татвар                               | 6.7              | 3.7          | 8.8               | 11.6        | 8.3        | 9.7        | 0.0         | 0.0         |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО                        | 28.9             | 29.6         | 2.2               | 1.9         | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| ХӨРӨНГИЙН ОРЛОГО                           | 0.0              | 0.0          | 0.3               | 0.3         | 0.0        | 0.0        | 0.0         | 0.0         |
| ТУСЛАМЖИЙН ОРЛОГО                          | 19.8             | 28.5         | 4.5               | 4.5         | 0.0        | 0.0        | 30.2        | 30.2        |

- Улсын төсвийн орлого 261.8 тэрбум төгрөгт хүрч 7.2 хувиар буюу 17.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын орлого 52.0 хувиар буюу 20.8 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 2.5 хувиар буюу 1.3 тэрбум, тусламжийн орлого 44.2 хувиар буюу 8.7 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн ч, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 20.0 хувиар буюу 9.3 тэрбум, онцгой албан татварын орлого 7.1 хувиар буюу 2.1 тэрбум, бусад татварын орлого 44.8 хувиар буюу 3.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.
- Орон нутгийн өсвийн орлого 37.7 тэрбум төгрөгт хүрч, 7.6 хувиар буюу 2.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Сэлэнгэ аймгийн нийт орлого 0.4 тэрбум, Орхон аймгийн нийт орлого 2.7 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэнд тус аймгуудын ашигт малтмалын өвц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл нөлөөлсөн байна. Нийслэлийн бусад татварын орлого 0.6 тэрбум, татварын бус орлого 0.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу биелсэн ч, хувь хүний орлогын албан татварын орлого 1.2 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, нийт дүнгээр 0.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давсан байна. Өмнөговь аймгийн орлого 0.5 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн нь лицензийн төлбөрийн орлогын биелэлттэй, Дархан-Уул аймгийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн нь хувь хүний орлогын албан татварын орлогын биелэлттэй холбоотой байна.
- Хүний хөгжлийн санд ашигт малтмалын өвц ашигласны төлбөрийн орлого 9.7 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 16.0 хувиар буюу 1.4 тэрбум төгрөгөөр илүү байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 75.9 тэрбум болж 1.6 хувиар буюу 1.2 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасалдсан байна. Нийгмийн даатгалын санд улсын төсвөөс олгох 30.2 тэрбум төгрөгийн татаасыг бүрэн олгосон байна.

## **Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт:**

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2010 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр 543.0 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 394.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөн өнөөс гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 378.1 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлага 69.6 хувийн, улсын төсвийн зарлага 247.9 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардал 62.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Халамжийн сангаас халамжийн тэтгэвэрт 9.8 тэрбум, жирэмсэн, амаржсан эхчүүдэд 3.4 тэрбум, алдарт эхийн одонтой эхчүүдэд 8.5 тэрбум, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлтөнд 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Орон нутгийн төсвийн зарлага 28.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 70.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүний хөгжлийн сангаас иргэдэд олгох бэлэн мөнгөнд зориулж 87.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Нийгмийн даатгалын сангийн өлөвлөгдсөн зардал 88.8 хувийн буюу 70.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

## **Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл**

| ӨСВИЙН ЗАРЛАГА                           | НЭГДСЭН ТӨСӨВ   |                |                  |              |             |               |               |
|--|-----------------|----------------|------------------|--------------|-------------|---------------|---------------|
|  | ӨО-ны           | жилийн         | 2010 ОНЫ 2-Р САР |              | ХУВЬ        |               | ӨРҮҮ          |
|  | мөн үеийн       | Төлөв.         | Төлөв.           | Гүйцэт.      | (4:3)       | (4:2)         | (4-3)         |
|  | 1               | 2              | 3                | 4            | 5           | 6             | 7             |
|  | (Тэрбум төгрөг) |                |                  |              |             |               |               |
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b> | <b>289.3</b>    | <b>2,785.6</b> | <b>543.0</b>     | <b>378.1</b> | <b>69.6</b> | <b>13.6</b>   | <b>-165.0</b> |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                     | <b>267.4</b>    | <b>2,168.6</b> | <b>443.8</b>     | <b>348.4</b> | <b>78.5</b> | <b>16.1</b>   | <b>-95.4</b>  |
| Бараа, үйлчилгээний зардал               | 141.4           | 1,050.9        | 195.1            | 145.4        | 74.5        | 13.8          | -49.7         |
| Цалин хөлс                               | 90.8            | 598.9          | 97.7             | 92.1         | 94.3        | 15.4          | -5.5          |
| Нийгмийн даатгалын шимтгэл               | 7.7             | 57.3           | 9.3              | 7.9          | 85.1        | 13.8          | -1.4          |
| Бараа, үйлчилгээний бусад зардал         | 50.7            | 452.0          | 97.4             | 53.3         | 54.7        | 11.8          | -44.1         |
| Зээлийн үйлчилгээний төлбөр              | 3.2             | 42.8           | 5.2              | 5.7          | 109.9       | 13.3          | 0.5           |
| Татаас ба шилжүүлэг                      | 122.7           | 1,074.8        | 243.5            | 197.3        | 81.0        | 18.4          | -46.2         |
| <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                  | <b>17.4</b>     | <b>518.4</b>   | <b>76.8</b>      | <b>23.6</b>  | <b>30.7</b> | <b>4.6</b>    | <b>-53.2</b>  |
| Дотоод эх үүсвэрээр:                     | 15.3            | 480.2          | 75.0             | 23.0         | 30.6        | 4.8           | -52.0         |
| Гадаад эх үүсвэрээр                      | 2.1             | 38.2           | 1.8              | 0.6          | 33.9        | 1.6           | -1.2          |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ                | 4.6             | 98.6           | 22.5             | 6.1          | 27.0        | 6.1           | -16.4         |
| <b>УРСГАЛ ТЭНЦЭЛ</b>                     | <b>-90.5</b>    | <b>234.8</b>   | <b>-145.1</b>    | <b>-36.6</b> | <b>25.2</b> | <b>(15.6)</b> | <b>108.5</b>  |
| <b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>                       | <b>-112.2</b>   | <b>-358.6</b>  | <b>-244.0</b>    | <b>-51.4</b> | <b>21.1</b> | <b>14.3</b>   | <b>192.7</b>  |

## **Эргэж төлөгдөх цэвэр зээл :**

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 2 дугаар сард олон улсын байгууллага, гадаадын хандивлагч орнуудаас 27.4 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 8.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан байна. Иргэдэд олгох бэлэн мөнгөний дэвтэр хэвлүүлэхэд хэд зориулж 875.4 сая өгрөг, гадаад паспорт хэвлүүлэхэд зориулж 240.0 сая төгрөгийн зээлийг улсын төсвөөс олгосон байна.

## **Төсвийн тэнцэл:**

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 36.6 тэрбум төгрөг, нийт тэнцэл 51.4 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 13.8 тэрбум төгрөг, нийт тэнцэл 14.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.